



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 0/643

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын  
55 дугаар сургуулийн эргэлтийн бус  
хөрөнгийг данснаас хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 6,177,899.15 /зургаан сая нэг зуун далан долоон мянга найман зуун ерэн есөн төгрөг арван таван мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурах бичгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 55 дугаар сургууль /Ч.Ганбилэг/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй номыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 55 дугаар сургууль /Ч.Ганбилэг/-д үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
 газрын даргын 2019 оны 10 дугаар  
 сарын 24 өдрийн 01/643 тоот тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 55 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон жил	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Ном, сурах бичиг	2011-2017	2-8 жил	ш	2,568	6,177,899.15	6,177,899.15			Эрүүл ахуйн шаардлага хангахгүй, ашиглах боломжгүй.	устгах
Номын фондын дүн					2,568	6,177,899.15	6,177,899.15	-	-		
<b>Нийт дүн</b>							<b>6,177,899.15</b>				
Актлах хөрөнгө							6,177,899.15				
Татан төвлөрүүлэх хөрөнгө							<b>0.00</b>				